

М-СНАТ™ - Бага насны хүүхдүүдэд зориулсан Аутизмийн шинэчилсэн асуулга

Ашиглах заавар

М-СНАТ™ нь 16-30 сартай бага насны хүүхдүүд Аутизмийн хүрээний эмгэгтэй (АХЭ) эсэхийг олж тогтооход зориулагдан батлагдсан сорил юм. М-СНАТ™ нь эрүүл хүүхдийн үзлэг- дүгнэлтэнд хэрэглэгдэж болох бөгөөд мөн тусгай болон бусад мэргэжилтнүүд энэ сорилыг АХЭ- гийн магадлалыг олж тогтооход ашиглаж болно. М-СНАТ™-ийн үндсэн зорилго нь үнэн эерэг хариуны тоог нэмэгдүүлэх бөгөөд өөрөөр хэлбэл АХЭ-ийн хамгийн олон тохиолдлыг олж тогтоох юм. Үүнээс болоод хариу нь эерэг гарах худал тохиолдлууд олон байдаг бөгөөд энэ нь АХЭ-тэй байж магадгүй гэж тодорхойлогдсон(гэдэг хариутай) бүх хүүхэд тэгж оношлогдоно гэсэн үг биш юм. Үүнийг шийдэхийн тулд бид М-СНАТ™-тай хамт ашиглагдах нэмэлт ярилцлагыг боловруулсан юм. Хэрэглэгчдэд анхааруулахад нэмэлт ярилцлага байгаа хэдий ч М-СНАТ™ -ийг даваагүй хүүхдүүдийн нилээд хэсэг нь АХЭ-тэй гэж оношлогдохгүй.Гэвч тэд бусад төрлийн хөгжлийн эмгэг, хоцрогдолтой байж болох талтай тийм ч учраас сорилыг даваагүй хүүхэд бүрт шинжилгээ хийлгэх хэрэгтэй.

Үнэлэх аргачлал

М-СНАТ™-ийн хариу нь 2 минутын дотор гардаг Нийтдээ 3 болон түүнээс дээш асуултанд унасан хүүхдүүд эсвэл 7 хамгийн чухал асуултуудын 2 ба түүнээс дээшид нь унасан (2, 5, 7, 9, 14, 15, ба 20) бага насны хүүхдийн АХЭ оношлодог мэргэжилтнээр оношлогоо хийлгэж дүгнүүлэх хэрэгтэй. Үүн дээр нэмээд, эмч, эцэг эх мөн бусад мэргэжилтнүүд АХЭ-тэй байж болзошгүй гэж бодож байгаа хүүхдүүд шинжлүүлэх хэрэгтэй, яагаад гэвэл ямар ч сорил 100% үнэн байхгүй. Худал эерэг хариуны тоог багасгахын тулд М-СНАТ™ -ийн нэмэлт ярилцлага тусгагдсан байгаа.

Энэ хүснэгт нь ‘Буруу хариултууд’-ыг харуулж байна. Хэрвээ хүүхэд нийтдээ 3 болон түүнээс дээш асуултанд эсвэл хамгийн чухал асуултуудын 2 ба түүнээс дээшид нь унасан бол АХЭ-тэй байх магадлалтай. Хараар тодруулсан, том үсгээр бичсэнүүд нь хамгийн чухал асуултууд юм.11, 18, 20 ба 22 сөргүүлсэн асуултууд юм.

1. Үгүй	2. ҮГҮЙ	3. Үгүй	4. Үгүй	5. ҮГҮЙ
6. Үгүй	7. ҮГҮЙ	8. Үгүй	9. ҮГҮЙ	10. Үгүй
11.Тийм	12. Үгүй	13. Үгүй	14. ҮГҮЙ	15. ҮГҮЙ
16. Үгүй	17. Үгүй	18. Тийм	19. Үгүй	20. ТИЙМ
21.Үгүй	22. Тийм	23. Үгүй		

Сорилыг давахын тулд асуултуудын ихэнхид нь , сөргүүлсэн асуултуудаас (11, 18, 20, and 22) бусдад нь ‘Тийм’ гэж хариулсан байх ёстой, сөргүүлсэн асуултууд нь ‘үгүй’ гэж хариулна.

Хэрэв хүүхэд сорилд тэнцэхгүй бол түүнтэй нэмэлт ярилцлагыг хийхийг зөвлөө.

Хүүхдийн нэр: _____

Төрсөн он, сар, өдөр: _____ Өнөөдрийн он, сар, өдөр: _____

Маягтыг бөглөж байгаа хүний нэр : _____

Хүүхдийн юу болох(Ямар хамааралтай болох): _____

М-ЧАТ™

Доорхийг таны хүүхэд ихэнхдээ ямар байдгийг харгалзан бөглөөрэй.Бүх асуултанд хариулахыг хичээнэ үү.Хэрэв тухайн үйлдэл ховор бол(Жишээлбэл:та ганц,2 удаа л ажигласан), хүүхэд хийдэггүй гэж хариулна уу.

1. Хүүхэд таны өвдгөн дээр суугаад савлуулах, хөөрч буулгах дуртай юу,?	Тийм	Үгүй
2. Таны хүүхэд бусад хүүхдүүдийг сонирхдог уу?	Тийм	Үгүй
3. Таны хүүхэд юман дээр авирах дуртай юу, жишээлбэл шатаар дээшээ авирах дуртай юу?	Тийм	Үгүй
4. Нуугдаж тоглох дуртай юу?	Тийм	Үгүй
5. Таны хүүхэд жүжиглэж тоглох жишээлбэл: утсаар ярих, хүүхэлдэйгээ асрах, эсвэл өөрөөр жүжиглэж тоглодог уу?	Тийм	Үгүй
6. Таны хүүхэд юм руу заах, юм асуухдаа долоовор хуруугаа ер нь ашигладаг уу?	Тийм	Үгүй
7. Таны хүүхэд заах, ямарваа зүйлийг сонирхож буйгаа илтгэхдээ долоовор хуруугаа ашигладаг уу?	Тийм	Үгүй
8. Таны хүүхэд жижиг тоглоомыг (Жишээлбэл: Машин, шоо) амандаа хийх, гартаа дэмий эргэлдүүлэх, унагаахаас өөрөөр зөв тоглож чадах уу?	Тийм	Үгүй
9. Хүүхэд чинь таньд (эцэг эхдээ) үзүүлэх гэж эд зүйлс авчирдаг уу?	Тийм	Үгүй
10. Нэг юм уу хоёр секундээс илүү таны нүд рүү хардаг уу?	Тийм	Үгүй
11. Дуу чимээнд хэтэрхий мэдрэмтгий мэт харагддаг уу?(Жишээлбэл: Чихээ таглах)	Тийм	Үгүй
12. Таны царайг харахаараа аль эсвэл таныг инээмсэглэхэд хариу инээмсэглэдэг үү?	Тийм	Үгүй
13. Таны хүүхэд таныг дууриадаг уу? (Жишээлбэл: Та царайгаа өөрчлөхөд тэр дууриадаг уу?)	Тийм	Үгүй
14. Түүнийг нэрээр нь дуудахад хариу үйлдэл үзүүлдэг үү?	Тийм	Үгүй
15. Таныг өрөөний нөгөө талд байгаа тоглоом руу заахад, тоглоом руу хардаг уу?	Тийм	Үгүй
16. Таны хүүхэд явдаг уу?	Тийм	Үгүй
17. Таны харж байгаа зүйл рүү хардаг уу?	Тийм	Үгүй
18. Нүүрнийхээ ойролцоо хуруунуудаараа сонин хөдөлгөөн хийдэг үү?	Тийм	Үгүй
19. Өөрийнхөө хийж байгаа зүйлд таны анхаарлыг хандуулахыг хичээдэг үү?	Тийм	Үгүй
20. Танд хүүхэд чинь дүлий юм болов уу гэдэг бодол төрж байсан уу?	Тийм	Үгүй
21. Хүүхэд чинь хүмүүсийн хэлж байгаа зүйлийг ойлгодог уу?	Тийм	Үгүй
22. Таны хүүхэд заримдаа хоосон газар руу гөлөрдөг үү, зориллогүй сэлгүүцдэг үү?	Тийм	Үгүй
23. Өөрт нь танил биш зүйлтэй тулгарахаараа таныг яаж хандаж байгааг харах гэж нүүр рүү чинь хардаг уу?	Тийм	Үгүй

© 1999 Diana Robins, Deborah Fein, & Marianne Barton

© 2011 Монгол хувилбарыг Evelien Meijners ба Эрдэнэбилэгийн Төгөлдөр хийв.